



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 11

Эрдэнэт

“Малын эрүүл мэнд” хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.“Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийг эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 10 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ